



САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Сэлэнгэ аймгийн Мандал сумын “Энх мэнд сувилал” ААТҮГ-ын 2021 оны
санхүүгийн тайланд хийсэн аудитын тайлан

Аудитын код: СЭА-2022/21-НА-СТА-ОНА

Цахим хуудас: Сүхбаатар сум 2022 он	Тэргүүлэх аудитор:	Ч.Энхтуяа
	Утас: 7036-3040	Цахим хаяг: Enkhtuyach@audit.gov.mn
	Аудитын менежер:	Б.Батмөнх
	Утас: 7036-3036	Цахим хаяг: Batmunkhb@audit.gov.mn
	Аудитор:	Т.Мөнхзул
	Утас: 7036-2442	Цахим хаяг: Munkhzult@audit.gov.com

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

Товчилсон үгийн жагсаалт

АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
ААНБ	Аж ахуйн нэгж байгууллага
ААТҮГ	Аж ахуйн тооцоотой үйлдвэрийн газар
ИТХТ	Иргэдийн төлөөлөгчдийн хурлын тэргүүлэгчид
ЗДТГ	Засаг даргын Тамгын газар
НББОУС	Нягтлан бодох бүртгэлийн Олон Улсын Стандарт
НДШ	Нийгмийн даатгалын шимтгэл
СТОУС	Санхүүгийн тайлагналын олон улсын стандарт
ТБОНӨБАУ	Төрийн болон орон нутгийн өмчөөр бараа ажил үйлчилгээ
ТЕЗ	Төсвийн ерөнхийлөн захирагч
ОНӨААТҮГ	Орон нутгийн өмчит аж ахуйн тооцоотой үйлдвэрийн газар
ХХОАТ	Хувь хүний орлогын албан татвар



**СЭЛЭНГЭ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

213200 Сэлэнгэ аймаг, Сүхбаатар сум
Цагаан Эрэг II баг
Утас: 7036-3040, Факс: (976)-7036-3040
E-mail: Selenge@audit.gov.mn

2022.03.15 № 017-2022/21-НА-СТА-ОНА

танай _____-ийн № _____-т

АУДИТЫН САНАЛ ДҮГНЭЛТ

Хязгаарлалттай дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.8-д заасны дагуу “Энх мэнд сувилал” ААТҮГ-ын 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, орлогын дэлгэрэнгүй, өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгуудад аудит хийлээ.

Дүгнэлтийн үндэслэл хэсэгт дурдсан алдаа, зөрчлийн үр нөлөөг эс тооцвол “Энх мэнд сувилал” ААТҮГ-ын 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайланг Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Санхүүгийн тайлагналын олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, шалгагдагч байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно. Үүнд:

- ААТҮГ-ын үйлдвэрлэл, санхүүгийн төлөвлөгөөг боловсруулж, холбогдох байгууллага, албан тушаалтнаар батлуулаагүй.
- Захирал А.Энхбилэгийн цалинг 950.0 мянган төгрөгөөр тогтоосон байхад төрийн үйлчилгээний албан хаагчийн ТҮЭМ6-5 цалингийн сүлжээгээр цалинжуулж, төрийн алба хаасан хугацааны болон ур чадварын нэмэгдлийг тус бүр 20 хувиар тооцож, нийт 2,303.6 мянган төгрөгийн нэмэгдэл цалин олгосон байна.

Эдгээр нь Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1.3 дахь “Үйлдвэрийн газрын үйлдвэрлэл, санхүүгийн төлөвлөгөө боловсруулж, зохих байгууллагаар батлуулан биелэлтийг хангах” гэсэн заалт болон Засгийн газрын 2018 оны 382 дугаар тогтоолоор баталсан “Төрийн захиргааны болон үйлчилгээний албан хаагчид төрийн алба хаасан хугацааны нэмэгдэл олгох

016020393

журам", "Төрийн үйлчилгээний албан хаагчид ур чадварын нэмэгдэл олгох нийтлэг журам", Сумын Засаг даргын 2021 оны 02 дугаар сарын 09-ны өдрийн Б/04 дүгээр захирамжийг тус тус зөрчсөн байна.

Бусад мэдээлэл

Тайлант онд үйлдвэрийн газрын үйл ажиллагааны төлөвлөгөө батлагдаагүй байна. Санхүүгийн тайланд өгсөн бидний дүгнэлт бусад мэдээллийг хамгаагүй ба үүнд ямар нэг төрлийн баталгаажуулах дүгнэлт гаргаагүй болно.

Удирдлага болон Засаглах эрх бүхий этгээдүүдийн санхүүгийн тайланд хүлээх үүрэг, хариуцлага

Удирдлага санхүүгийн тайланг Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Санхүүгийн тайлагналын олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт гэдэг нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гаргах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Ч.ЭНХТУЯА

2.Аудит хийсэн санхүүгийн тайлан

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

/ төгрөгөөр/

№	Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ХӨРӨНГӨ	-	-
1.1.1	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгө	-	856,155.80
1.1.6	Бараа материал	-	6,279,490.00
1.1.11	Эргэлтийн хөрөнгийн дүн	-	7,135,645.80
1.2.1	Үндсэн хөрөнгө	-	1,813,900.00
1.2.10	Эргэлтийн бус хөрөнгийн дүн	-	1,813,900.00
1.3	Нийт хөрөнгийн дүн	-	8,949,545.80
2	ӨР ТӨЛБӨР БА ЭЗДИЙН ӨМЧ	-	-
2.1	ӨР ТӨЛБӨР	-	-
2.1.1	БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	-	-
2.1.1.3	Татварын өр	-	37,707.56
2.1.1.13	Богино хугацаат өр төлбөрийн дүн	-	37,707.56
2.2	Өр төлбөрийн нийт дүн	-	37,707.56
	ЭЗДИЙН ӨМЧ	-	0.00
2.3	Өмч	-	5,178,790.00
2.3.1	-төрийн	-	5,178,790.00
2.3.9	Хуримтлагдсан ашиг	-	3,733,048.24
2.3.11	Эздийн өмчийн дүн	-	8,911,838.24
2.4	Өр төлбөр ба эздийн өмчийн дүн	-	8,949,545.80

2.2 Аудит хийсэн дэлгэрэнгүй орлогын тайлан

№	Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	Борлуулалтын орлого (цэвэр)	-	36,120,000.00
2	Борлуулалтын өртөг	-	-
9	Борлуулалт, маркетингийн зардал	-	-
10	Ерөнхий ба удирдлагын зардал	-	32,349,244.20
18	Татвар төлөхийн өмнөх ашиг (алдагдал)	-	3,770,755.80
19	Орлогын татварын зардал	-	37,707.56
20	Татварын дараах ашиг (алдагдал)	-	3,733,048.24
21	Зогсоосон үйл ажиллагааны татварын дараах ашиг (алдагдал)	-	-
22	Тайлант үеийн цэвэр ашиг (алдагдал)		3,733,048.24
23	Бусад дэлгэрэнгүй орлого	-	-
23.1	Хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдлийн зөрүү	-	-
23.2	Гадаад валютын хөрвүүлэлтийн зөрүү	-	-
23.3	Бусад олз (гарз)	-	-
24	Орлогын нийт дүн		
25	Нэгж хувьцаанд ногдох суурь ашиг (алдагдал)	-	-

2.3 Аудит хийсэн өмчийн өөрчлөлтийн тайлан

/төгрөгөөр/

№	Үзүүлэлт	Өмч	Эздийн өмчийн бусад хэсэг	Хуримтлагдсан ашиг	Нийт дүн
1	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлтийн нөлөө, алдааны залруулга	-	-	-	-
2	Залруулсан үлдэгдэл	5,178,790.00	-	-	5,178,790.00
3	Тайлант үеийн цэвэр ашиг (алдагдал)	-	-	3,733,048.24	3,733,048.24
7	Дахин үнэлгээний нэмэгдлийн хэрэгжсэн дүн	-	-	-	-
8	20.. оны 12-р сарын 31-ны үлдэгдэл	5,178,790.00		8,911,838.24	8,911,838.24

2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

№	Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ҮНДСЭН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ	-	-
1.1	Мөнгөн орлогын дүн	-	36,120,000.00
1.1.1	Бараа борлуулсан, үйлчилгээ үзүүлсний орлого	-	33,120,000.00
1.1.5	Татаас, санхүүжилтийн орлого	-	3,000,000.00
1.2	Мөнгөн зарлагын дүн	-	35,263,844.20
1.2.1	Ажиллагчдад төлсөн	-	15,963,644.00
1.2.2	Нийгмийн даатгалын байгууллагад төлсөн	-	3,529,172.20
1.2.3	Бараа материал худалдан авахад төлсөн	-	10,354,200.00
1.2.5	Түлш шатахуун, тээврийн хөлс, сэлбэг хэрэгсэлд төлсөн	-	149,100.00
1.2.7	Татварын байгууллагад төлсөн	-	1,462,628.00
1.2.9	Бусад мөнгөн зарлага	-	3,805,100.00
1.3	Үндсэн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн		856,155.80
3	САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ		0.00
3.1	Мөнгөн орлогын дүн		0.00
3.2	Мөнгөн зарлагын дүн		0.00
4.1	Бүх цэвэр мөнгөн гүйлгээ		856,155.80
5	МӨНГӨ, ТҮҮНТЭЙ АДИЛТГАХ ХӨРӨНГИЙН ЭХНИЙ ҮЛДЭГДЭЛ		0.00
6	МӨНГӨ, ТҮҮНТЭЙ АДИЛТГАХ ХӨРӨНГИЙН ЭЦСИЙН ҮЛДЭГДЭЛ		856,155.80

2.5 Эдийн засгийн үндсэн үзүүлэлт, зорилтот түвшний гүйцэтгэл

№	Үзүүлэлт	Хэмжих нэгж	2020 оны гүйцэтгэл	2021 оны		Зөрүү	Хувь
				Төлөвлөгөө	Гүйцэтгэл		
1	Үйлдвэрлэлийн үндсэн үзүүлэлт				36,120,000.00		
2	Нийт орлого	м/төгрөг	-	-		-	-
	Үүнээс: Цэвэр борлуулалт	м/төгрөг	-	-	33,120,000.00	-	-
	Үндсэн бус үйл ажиллагааны орлого	м/төгрөг	-	-	3,000,000.00	-	-
3	Нийт зардал	м/төгрөг	-	-	32,349,244.20	-	-
	Үүнээс: а) Борлуулсан бүтээгдэхүүний өртөг	м/төгрөг	-	-		-	-
	б) Ерөнхий ба удирдлагын зардал	м/төгрөг	-	-	32,349,244.20	-	-
	в) Хөрөнгө оруулалт их засвар	м/төгрөг	-	-	-	-	-
4	Цэвэр ашиг, алдагдал	м/төгрөг	-	-	3,733,048.24	-	-

3. Санхүүгийн тайлангийн тодруулга

3.1 Байгууллагын үйл ажиллагаа

“Энх мэнд сувилал” ААТҮГ нь “Ахмад настануудыг чанар сайтай амин дэмтэй хоол хүнсээр сувилж, эрүүл чийрэг урт удаан наслахад дэмжлэг болно” гэсэн эрхэм зорилготойгоор тайлант онд үйл ажиллагаа явуулсан байна.

“Энх мэнд сувилал” ААТҮГ-ын дүрэмд тус байгууллагын үйл ажиллагааны чиглэлийг дараах байдлаар тодорхойлжээ. Үүнд:

- Ахмад настан тэдний эрүүл мэндийг дэмжих, эрүүл мэндийн боловсрол олгох, нийгмийн эрүүл мэндийн тусламж үйлчилгээг зохион байгуулж ажиллах,
- Ажлын байрны ашиглалт, эрүүл ахуйн нөхцөл, хүнсний бүтээгдэхүүний чанар аюулгүй байдал, стандартуудыг ханган ажиллахад мэргэжлийн байгууллагуудын зөвлөмж, дүгнэлтийг үйл ажиллагаандаа тусган ажиллах
- Туслах үйл ажиллагаа гэх мэт.

3.2 Байгууллагын үйл ажиллагаа явуулж буй эрх зүйн орчин

“Энх мэнд сувилал” ААТҮГ-ыг Мандал сумын ИТХТ-ийн 2021 оны 02 дугаар сарын 04- ний өдрийн 15 дугаар тогтоолоор байгуулсан байна. Энэ нь Монгол улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 18 дугаар СЭА-2022/21-НА-СТА-ОНА

зүйлд “Сум, дүүргийн Хурлын бүрэн эрх”, 18 дугаар зүйлийн 18.1.3 ж-д “Орон нутгийн өмчит хуулийн этгээд байгуулах, өөрчлөн байгуулах, татан буулгах шийдвэр гаргах, **дүрмийг батлах**”, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 77 дугаар зүйлийн 77.2-д “Орон нутгийн өмчийг эзэмших, ашиглах, захиран зарцуулах талаар иргэдийн Төлөөлөгчдийн Хурал дараах бүрэн эрхтэй:... 4/ **орон нутгийн өмчийн хуулийн этгээд байгуулах, өөрчлөн байгуулах, татан буулгах шийдвэр гаргаж, гүйцэтгэлд нь хяналт тавих**” гэсэн заалттай нийцэж байна.

Тайлант хугацаанд байгууллагын санхүүгийн үйл ажиллагаанд мөрддөг хууль, тогтоомж, бодлого, журамд дараах өөрчлөлтүүд орсон байна. Үүнд:

- УИХ-аас 2021 оны 6 дугаар сард Нийгмийн даатгалын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 3 дахь хэсэгт заасан даатгуулагчийн сард төлбөл зохих нийгмийн даатгалын шимтгэлийн доод хэмжээ нь Засгийн газраас баталсан тухайн үед мөрдөж байгаа хөдөлмөрийн хөлсний доод хэмжээний тэтгэврийн даатгалд 11.5 хувиас, тэтгэмжийн болон үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчний даатгалд тус бүр 1.0 хувиас багагүй байна гэж өөрчлөлт оруулсан,
- Засгийн газрын 2021 оны 43 дугаар тогтоол “Төсвийн хэмнэлтийн талаар авах арга хэмжээний тухай”,
- Засгийн газрын 2021 оны 124 дүгээр тогтоол “ТБОНӨХБАҮ худалдан авах босго үнэ шинэчлэн тогтоох тухай” гэх мэт

3.3 Нягтлан бодох бүртгэлийн бодлого

“Энх мэнд сувилал” ААТҮГ-ын 2021 оны санхүүгийн тайлангаа эж ахуйн нэгжийн санхүүгийн тайлангийн батлагдсан маягтаар тайлагнаж, Нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын зөвлөлөөс баталсан Санхүүгийн тайлагналын олон улсын стандартад нийцүүлээ.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

/мянган төгрөгөөр/			
Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Мөнгөн хөрөнгө	-	856.1	856.1
Бараа материал	-	6,279.5	6,279.5
Үндсэн хөрөнгө	-	1,813.9	1,813.9
Нийт хөрөнгө	-	8,949.5	8,949.5
Өр төлбөр	-	37.7	37.7
Өмч	-	-	-
-Төрийн		5,178.8	5,178.8
/-/ Хуримтлагдсан ашиг/+/ , алдагдал		3,733.0	3,733.0
Нийт өр төлбөр ба цэвэр хөрөнгө өмчийн дүн	-	8,949.5	8,949.5

Төрийн болон Хаан банкин дахь харилцах дансанд 36,120.0 мянган төгрөгийн орлого төвлөрч, 35,263.9 мянган төгрөгийн зарлага гарган 856.1 мянган төгрөгийн үлдэгдэлтэй тайлагнагдсан байна.

Мандал сумын ЗДТГ-аас 5,178.8 мянган төгрөгийн үнэ бүхий бараа материал шилжүүлэн авч, сумын Засаг даргын нөөц хөрөнгийн эх үүсвэрээс 1,100.7 мянган төгрөгийн бараа материал худалдан авч, 6,279.5 мянган төгрөгийн үлдэгдэлтэй тайлагнагдсан байна.

Тус сувилал нь хөлдөөгч, тасалгаа ариутгагч, шарлагын гэрэл зэрэг 1,813.9 мянган төгрөгийн үндсэн хөрөнгийг худалдан авч, хөрөнгийн дансанд бүртгэсэн байна.

ААНБ-ын орлогын албан татварыг барагдуулаагүйгээс богино хугацаат өр төлбөр данс 37.7 мянган төгрөгийн үлдэгдэлтэй тайлагнагдсан байна.

Тус сувилалд амарч сувилуулсан 157 иргэнээс 11,700.0 мянган төгрөг, халамжийн сангаас сувилуулсан 153 ахмадын 21,420.0 мянган төгрөгийн хөнгөлөлтийн төлбөр, сумын Засаг даргын нөөц хөрөнгөөс санхүүгийн дэмжлэгийн 3,000 мянган төгрөг зэрэг нийт 36,120.0 мянган төгрөгийн орлого олж, үйл ажиллагааны зардалд 32,349.3 мянган төгрөгийг зарцуулж 3,733.0 мянган төгрөгийн ашигтай ажилласан байна.

3.4. Техник, эдийн засгийн үзүүлэлт, зорилтот түвшний гүйцэтгэл

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1.3-д заасны дагуу “Энх мэнд сувилал” ААТҮГ нь байгууллагын үйлдвэрлэл, санхүүгийн төлөвлөгөө боловсруулж, зохих байгууллагаар батлуулж, биелэлтийг хангах үүрэгтэй.

“Энх мэнд сувилал” ААТҮГ-нь 2021 оны үйлдвэрлэл, санхүүгийн төлөвлөгөөг боловсруулж, батлуулалгүйгээр үйл ажиллагаа явуулсан бөгөөд гүйцэтгэлээр 36,120.0 мянган төгрөгийн орлого бүрдүүлж, 32,349.3 мянган төгрөгийн зардал гарган, 3,733.0 мянган төгрөгийн ашигтай ажилласан байна.

4. Аудитын тайлан

4.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана.” гэж заасны дагуу Энх мэнд сувилал аж ахуйн тооцоотой үйлдвэрийн газар /цаашид Энх мэнд сувилал ААТҮГ гэх/-ын 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайланд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд шалгадагч этгээд, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын талаар болон аудитын явцад илрүүлсэн алдаа, зөрчил, гаргасан

шийдэл, анхаарал татахуйц бусад чухал асуудал болон аудитын санал дүгнэлт, түүний үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Энэхүү тайланд шалгагдагч этгээдэд аймгийн ТЕЗ-аас боловсруулсан Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийг мөрдөн ажиллах, ажилчдын цалингаас НДШ суутгаж бүрэн тайлагнах, жолоочийн тооцооны хуудас хөтлөх, өр төлбөрийг хянаж бараа материалын худалдан авалтыг холбогдох үзүүлэлтүүдийг тусгасан төлбөрийн баримтаар баталгаажуулах, бараа материалыг шаардах хуудсаар олгож, зарцуулж тайлагнаж байх зөвлөмжүүдийг хүргүүлээ.

Аудитыг Сэлэнгэ аймаг дахь Төрийн аудитын газрын аудитор Т.Мөнхзул гүйцэтгэж, хяналтыг аудитын менежер Б.Батмөнх, дарга, тэргүүлэх аудитор Ч.Энхтуяа нар тус тус хэрэгжүүлсэн.

“Энх мэнд сувилал” ААТҮГ-ын 2021 оны санхүүгийн тайланг Сэлэнгэ аймаг дахь Төрийн аудитын газарт 2022 оны 01 дүгээр сарын 28-ны өдрийн 01 дүгээр албан бичгээр ирүүлсэн байна.

4.2 Дотоод хяналт

Үйлдвэрийн газрын удирдлагын хэрэгжүүлж байгаа дотоод хяналтуудаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэлийн үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилтийн үр нөлөө сул байна гэж дүгнэж байна. Үүнд:

- 2021 оны үйлдвэрлэл, санхүүгийн төлөвлөгөө, үйлдвэрийн газрын бүтэц, орон тоо, зохион байгуулалт, цалингийн болон бусад зардлыг төлөвлөж, холбогдох байгууллагаар батлуулаагүй,
- ТЕЗ-аас баталсан Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийг мөрдөж ажиллаагүй,
- Үйлдвэрийн газрын тайлант жилийн үйл ажиллагааны үр дүнг холбогдох байгууллагад танилцуулж, үнэлэлт дүгнэлт өгөгдөөгүй байна.

“Энх мэнд сувилал” ААТҮГ-ын хувьд дотоод аудитын нэгж, хариуцсан ажилтангүй бөгөөд тайлант жилийн хугацаанд хяналт, шалгалт хийгдээгүй байна.

4.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор санал дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

“Энх мэнд сувилал” ААТҮГ-ын 2021 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккрузл сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн байна.

4.4 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр тайлант оны орлогын дэлгэрэнгүй тайлангийн борлуулалтын орлогыг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэл “дунд” гэж үнэлэн материаллаг байдлын түвшинг 1.5 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2021 оны орлогын дэлгэрэнгүй тайлангийн борлуулалтын нийт орлого 36,120.0 мянган төгрөгөөс 1.5 хувиар буюу 541.8 мянган төгрөгөөр тогтоосон.

Тогтоосон төлөвлөлтийн ерөнхий материаллаг байдлыг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзсэн болно.

5. Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайлангийн аудитын санал дүгнэлтээс тусад нь салгах ёстой гэж заасан байна.

5.1 Шилэн дансны мэдээлэл

Шилэн дансны тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.1.1, 3.1.2-т хамаарах төсөвт байгууллага, төрийн болон орон нутгийн өмчит үйлдвэрийн газар нь 3 дугаар зүйлийн 6.1, 6.4-т тус тус тусгасан мэдээллийг хуульд заасан хугацаанд ил тод мэдээлэх зохицуулалттай.

“Энх мэнд сувилал” ААТҮГ нь 2021 оны 8 дугаар сараас үйл ажиллагаа явуулж эхэлсэн боловч шилэн дансны нэгдсэн мэдээллийн санд цахим хаяг нээлгээгүй байгаа нь Шилэн дансны тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.1 дэх “Доор дурдсан байгууллага, түүний эд хөрөнгө захиран зарцуулах эрх бүхий албан тушаалтан энэ хуулийн үйлчлэлд хамаарна. 3.1.1: Төрийн болон орон нутгийн өмчит хуулийн этгээд” 7.1 дэх “Шилэн дансны мэдээллийг энэ хуулийн дагуу иргэн олон нийтэд хүргэх үүргийг дараах албан тушаалтан хүлээнэ”, 7.1.3: Тухайн зарлага, төлбөрийн даалгаварт нэгдүгээр, хоёрдугаар гарын үсэг зурж гүйлгээ хийсэн албан тушаалтан” гэсэн заалтуудыг тус тус зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн нь: Шилэн дансны нэгдсэн мэдээллийн санд цахим хаяг нээлгэж, Шилэн дансны тухай хуулийг хэрэгжүүлэн ажиллах албан шаардлага хүргүүлэх.

5.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд

Засгийн газрын 2021 оны 43 дугаар “Төсвийн хэмнэлтийн талаар авах арга хэмжээний тухай” тогтоолын 1.3-д “Төрийн болон орон нутгийн өмчит, тэдгээрийн оролцоотой аж ахуйн нэгж, байгууллагын дотоод зохион байгуулалтын бүтэц,

чиг үүргийг оновчтой тодорхойлж, орон тоо, чиг үүргийн давхардлыг арилгаж, төсөв, зардлыг хэмнэсэн байхаар шинэчлэх, удирдлагын цалин хөлсийг орлого, үр ашигтай нь уялдуулан, үйл ажиллагааны чиглэл, цар хүрээ, түвшин зэргийг харгалзан нэг хэлбэр, нийтлэг жишгээр ангилан тогтоодог зарчимд шилжих, цалин хөлсийг нэмэгдүүлэхгүй, шагнал, урамшуулал олгохгүй байх, зочин төлөөлөгч хүлээн авах, бэлэг дурсгал (цүнх, календарь, мэндчилгээ г.м)-ын зардлыг гаргахгүй байх” гэж заасны дагуу шагнал урамшуулал олгоогүй, зочин төлөөлөгч хүлээн авах болон бэлэг дурсгалын зардал гаргаагүй байна.

6. Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

Тайлант онд шинээр үүсгэн байгуулагдаж үйл ажиллагаа явуулсан тул өмнөх оны мэдээлэл байхгүй болно.

7. Дараагийн аудитаар анхаарах асуудал

Анхаарал татсан асуудал үгүй байна.

8. Аудитын илрүүлэлт

Аудитаар нийт 20369.3 мянган төгрөгийн 7 алдаа зөрчил илэрснээс аудитын явцад 1,100.7 мянган төгрөгийн алдааг залруулж, 2,303.6 мянган төгрөгийн 2 зөрчилд албан шаардлага, 16,965.0 мянган төгрөгийн зөрчил 4 зөвлөмж өгөгдлөө.

8.1 Залруулсан алдаа

- 2021 оны санхүүгийн тайланд 1,100.7 мянган төгрөгийн аж ахуйн зориулалттай материалыг үндсэн хөрөнгийн дансанд бүртгэсэн.

8.2 Албан шаардлага

1. Үйлдвэрийн газрын 2021 оны үйлдвэрлэл, санхүүгийн төлөвлөгөөг боловсруулж, батлуулаагүй байгаа нь Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1.3 дахь “үйлдвэрийн газрын үйлдвэрлэл, санхүүгийн төлөвлөгөө боловсруулж, зохих байгууллагаар батлуулан биелэлтийг хангах” гэсэн заалттай нийцэхгүй бөгөөд санхүүгийн тайлангийн “Нийцсэн бөгөөд зохистой байх” батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Үйлдвэрлэл, санхүүгийн төлөвлөгөө боловсруулж, холбогдох байгууллагаар батлуулж, мөрдөх албан шаардлага хүргүүлэх.

2. “Энх мэнд сувилал” ААТҮГ-ын захирал А.Энхбилэгийн цалинг 950.0 мянган төгрөгөөр тогтоосон байхад төрийн үйлчилгээний албан хаагчийн ТҮЭМБ-5 цалингийн сүлжээгээр цалинжуулж, төрийн алба хаасан хугацааны болон үр чадварын нэмэгдлийг тус бүр 20 хувиар тооцож, 9-12 сард нийт 2,303.6 мянган төгрөгийн нэмэгдэл цалин олгосон байна. Энэ нь Засгийн газрын 2018 оны 382 дугаар тогтоолын 1 дүгээр хавсралтаар баталсан “Төрийн захиргааны болон үйлчилгээний албан хаагчид төрийн алба хаасан хугацааны нэмэгдэл олгох

журам”, 4 дүгээр хавсралтаар баталсан “Төрийн үйлчилгээний албан хаагчид ур чадварын нэмэгдэл олгох нийтлэг журам”, Сумын Засаг даргын 2021 оны 02 дугаар сарын 09-ны өдрийн Б/04 дүгээр захирамжтай нийцэхгүй бөгөөд санхүүгийн тайлангийн “Нийцсэн бөгөөд зохистой байх” батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Цаашид тогтоосон цалин хөлсийг баримталж ажиллах албан шаардлага хүргүүлэх.

8.3 Зөвлөмж

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

1. Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичигтэй холбоотой асуудал

Илрүүлэлт: Аймгийн ТЭЗ буюу Засаг даргын 2021 оны А/58 дугаар захирамжаар батлагдсан “Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг”-ийг бүртгэлийн үйл ажиллагаанд мөрдөж, ажиллаагүй байгаа нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.2 дахь “Аж ахуйн нэгж, байгууллагын удирдлага нь нягтлан бодох бүртгэлийн хууль тогтоомж, стандарт, дүрэм, журам, зааварт нийцүүлэн нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийг ..., мөрдөж ажиллана” гэж заасантай нийцээгүй бөгөөд санхүүгийн тайлангийн “Нийцсэн бөгөөд зохистой байх” батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Өгсөн зөвлөмж: Аймгийн Засаг даргын 2021 оны А/58 тоот захирамжаар батлагдсан “Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг”-ийг бүртгэлийн үйл ажиллагаанд мөрдөж ажиллах.

2. Цалин хөлстэй холбоотой асуудал

Илрүүлэлт Үйлчилгээний 3 албан хаагчийг хөдөлмөрийн хөлсний доод хэмжээнээс багаар буюу 350.0-390.0 мянган төгрөгөөр цалинжуулж нийт 4,130.0 мянган төгрөгийн цалингаас ХХОАТ тооцож, НДШ-ийг суутгаагүй, НДШ-ийн тайланд тайлагнаагүй байгаа нь НДШ-ийн өр төлбөр үүсэх эрсдэлийг үүсгэж байна. Энэ нь Нийгмийн даатгалын тухай хуулийн 17 дугаар зүйл 17.1.1 дэх “Ажил олгогч нь хөдөлмөрийн хөлсний сан, түүнтэй адилтгах орлого болон түүнд оногдох шимтгэлийг үнэн зөв тодорхойлж, тогтоосон хугацаанд төлөх” гэсэн заалтыг зөрчсөн бөгөөд санхүүгийн тайлангийн “Нийцсэн бөгөөд зохистой байх” батламж мэдэгдлийг хангаагүй байна.

Өгсөн зөвлөмж: Ажилчдын цалин хөлсийг холбогдох хууль, эрхийн актын хүрээнд тогтоох, цалингаас НДШ суутгаж бүрэн тайлагнаж байх.

3. Анхан шатны баримттай холбоотой асуудал

3.1.1 Илрүүлэлт: Тайлант онд 2,480.8 мянган төгрөгийн бараа материалын худалдан авалтыг холбогдох үзүүлэлтүүдийг тусгасан төлбөрийн баримтаар баталгаажуулаагүй, цахим системд шивэгдээгүй байна.

3.1.2 Өгсөн зөвлөмж: Энэ нь Татварын ерөнхий хуулийн 28 дугаар зүйл 28.5 дахь “Татвар төлөгч борлуулалт хийх тухай бүрд хэрэглэгчийн системээс дахин давтагдашгүй дугаар бүхий төлбөрийн баримтыг хэвлэж өгөх, эсхүл цахимаар илгээх үүрэгтэй” гэсэн заалтыг болон Сангийн сайдын 2017 оны 347 дугаар тушаал 1 дүгээр хавсралтын 6.5 дахь “Төлбөрийн баримт нь бараа, ажил, үйлчилгээний төлбөр, тооцоо хийгдсэнийг нотлох анхан шатны цаасан болон цахим баримт юм. Төлбөрийн баримтад борлуулагч, худалдан авагчийг таних тэмдэг, татвар төлөгчийн дугаар, төлбөр тооцоо хийгдсэн он, сар, өдөр, бараа, ажил, үйлчилгээний нэр, код, тоо хэмжээ, үнэ, татварын дүнг тусгана. Төлбөрийн баримтыг цахим гарын үсэг эсхүл тусгай нууцлалын QR кодоор баталгаажуулах бөгөөд Монгол Улсын Стандарт MNS 6529:2015 “Татварын нэгдсэн системд ашиглах төлбөрийн баримтын ерөнхий шаардлага”-д заасан загварын дагуу бүртгэлийн машинаар хоёр хувь үйлдэнэ” гэж заасныг зөрчсөн ба “Нийцсэн бөгөөд зохистой байх” батламж мэдэгдлийг хангахгүй байна.

3.2.1 Илрүүлэлт: Тус сувилал нь 10,354.2 мянган төгрөгийн бараа материалыг зарцуулахдаа шаардах хуудас болон жолоочийн тооцооны хуудасгүйгээр шатахууныг зарцуулж, тайлагнасан байна.

3.2.2 Өгсөн зөвлөмж: Сангийн сайдын 2017 оны 347 дугаар тушаалаар баталсан “Өмчийн бүх хэлбэрийн аж ахуйн нэгж, байгууллагад нийтлэг хэрэглэгдэх анхан шатны бүртгэлийн маягтыг нөхөх заавар”-ын 3.6 “Материалын үнэ бүхий зүйлсийг байгууллагын үйлдвэрлэл, дотоод хэрэгцээнд зарцуулах шаардлага гарсан үед уг зүйлийг авч зарцуулах хүн “Шаардах хуудас”-ыг 1 хувь үйлдэж зөвшөөрөл авна. Эд хариуцагч шаардах хуудсыг үндэслэн материал, үнэ бүхий зүйлийг тавьж олгосны дараа агуулахын бүртгэлд бичилт хийж, тайлант хугацаанд нягтлан бодогчид хүргүүлнэ.” гэж заасны дагуу бараа материалыг зарцуулахдаа тухай бүрд хариуцагч, албан хаагч тус бүрээр шаардах хуудас үйлдүүлж, холбогдох албан тушаалтнаас зөвшөөрөл авсны дараа олгож байх.

Дээрх зөвлөмжийн биелэлтийг Сэлэнгэ аймаг дахь Төрийн аудитын газарт 2022 оны 06 дугаар сарын 01-ний өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье

9. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл

/мянган төгрөгөөр/														
д/д	Байгууллагын нэр	Аудитын код	Алдаа зөрчлийн утга	Нийт алдаа, зөрчлийн дүн		Үүнээс								Зөвлөмж
						Залруулга		Акт		Албан шаардлага		Хариуцлага тооцох		
				Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо
Санхүүгийн тайлангийн асуудлаар														
1	“Энх мэнд сувилал” ААТҮГ	СЭА-2022/21-НА-СТА-ОНА	2021 оны үйлдвэрлэлийн болон санхүүгийн төлөвлөгөөг боловсруулж батлуулаагүй.	1						1				
2	“Энх мэнд сувилал” ААТҮГ	СЭА-2022/21-НА-СТА-ОНА	Захирал А.Энхбилэгийн цалин хөлсийг төрийн үйлчилгээний эрүүл мэндийн албан тушаалын цалингийн сүлжээгээр тооцож нэмэгдэл хөлс олгосон	1	2,303.6					1	2,303.6			
3	“Энх мэнд сувилал” ААТҮГ	СЭА-2022/21-НА-СТА-ОНА	Аймгийн Засаг даргын 2021 оны А/58 тоот захирамжаар “Нягтлан батлагдсан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийн жишиг заавар”-ыг мөрдөөгүй байна.	1								1		
4	“Энх мэнд сувилал” ААТҮГ	СЭА-2022/21-НА-СТА-ОНА	Үйлчилгээний 3 албан хаагчийг хөдөлмөрийн хөлсний доод хэмжээнээс багаар буюу 350,0-390.0 мянган төгрөгөөр цалинжуулж цалингаас зөвхөн ХАОАТ тооцож, НДШ-ийг суутгаагүй	1	4,130.0							1	4,130.0	

Энх мэнд сувилал ААТҮГ-ын 2021 оны санхүүгийн тайлангийн аудитын тайлан

			Барaa материалын худалдан авалтыг холбогдох үзүүлэлтүүдийг тусгасан төлбөрийн баримтаар баталгаажуулаагүй, цахим системд шивэгдээгүй	1	2,480.8													1	2,480.8		
			Барaa материалыг шаардах хуудсаар олгоогүй буюу анхан шатны баримтын бүрдэлгүйгээр ажил гүйцэтгэж, бүртгэл тайланд тусгасан.	1	10,342.2													1	10,354.2		
8				1	1,100.7	1	1,100.7											2	2,303.6	4	16,965.0
Санхүүгийн тайлангийн асуудлаар шалгасан нийцлийн асуудал																					
8	"Энх мэнд" ААТҮГ	СЭА-2022/18-НА-СТА-ОНА	Шилэн дансны нэгдсэн мэдээллийн санд цахим хаяг нээлгээгүй.	1														1			
	ДҮН			1														1			
	НИЙТ ДҮН			8	20,369.3	1	1,100.7											3	2,303.6	4	16,953.0